

ХҮҮХДЭД АЮУЛГҮЙ ОЛОН НИЙТИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Энэхүү Ёс зүйн дүрмийн хамгийн гол асуудал бол хүүхдийн аюулгүй байдал бөгөөд эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд, олон нийтээс мэдээллийг хэд хэдэн хэлбэрээр ирүүлж болно.

Энэхүү Ёс зүйн дүрэм нь Parramatta хотын зөвлөлийн сургуулийн өмнөх боловсролын төв, номын сан, олон нийтийн төв, байгууламж, амралт чөлөөт цагийн төв, түрээсийн газар зэрэг Зөвлөлийн байгууламж, үйлчилгээг ашиглаж буй бүх хүн, байгууллагад хамаарна.

Зөвлөлийн Хүүхдэд аюулгүй дүрэм журмын хүрээнд хүүхэд гэж 18 нас хүрээгүй аливаа хүнийг хэлнэ.

Бид дараах зүйлийг хийнэ:

- ✓ Хүүхэд залуучуудад хүндэтгэлтэй хандаж, тэдний санаа, бодлыг үнэлэх.
- ✓ Хүүхэд залуучуудтай харилцахдаа эерэг үлгэр дууриал болох.
- ✓ Хүүхэд залуучуудын биед шаардлагагүй хүрэхээс зайлсхийх.
- ✓ Хэрэв хүүхэд хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй бол цагдаад хандах - утасны дугаар 000.
- ✓ Хүүхэд эсвэл залуу хүнд ноцтой хохирол учрах эрсдэлтэй байна гэсэн үндэслэл бүхий сэжиг байвал Зөвлөлийн ажилтан эсвэл Хүүхэд хамгааллын тусламжийн 132 111 дугаарын утсаар мэдэгдэх.

Бид дараах зүйлийг хийхгүй:

- ✗ Хүүхэд залуучуудыг ичээж, доромжилж, зонхилж, үл ойшоож, гутаах.
- ✗ Аливаа хүүхдийг хууль бусаар ялгаварлан гадуурхах.
- ✗ Хүүхэд эсвэл залуу хүнд бие, сэтгэл санааны хувьд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийх.
- ✗ Хүүхдийн өмнө санаатайгаар хувцсаа тайлах, ямар нэгэн байдлаар бэлгэ эрхтэнээ ил гаргах.
- ✗ Хүүхэдтэй сээтэгнэж, бэлгийн санаа сэдэл өгөх.
- ✗ Бэлгийн шинж чанартай хошигнол хэлж, санаа сэдэл өгөх.
- ✗ Тодорхой хүүхэд эсвэл залуу хүнтэй хэрэгцээнд нь зориулсан “онцгой” харилцааг хөгжүүлж, уруу татах.
- ✗ Таны асран хамгаалж, хариуцаж буй хүүхдүүдээс гадуурх хүүхэд, залуучуудтай холбоо тогтоох, тэр дундаа онлайн харилцаа холбоо тогтоох.
- ✗ Хүүхэд болон түүний эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр хүүхэд, залуучуудын зураг авах, видео бичлэг хийх.
- ✗ Хүүхдүүдийн дэргэд насанд хүрсэн хүмүүсийн шинж чанартай нээлттэй хэлэлцүүлэгт оролцох.
- ✗ Хүүхдүүдийн дэргэд зохисгүй үг хэллэг ашиглах.
- ✗ Хүүхдийг хүслийнх нь эсрэг ямар нэгэн зүйл хийхийг албадах.
- ✗ Таны асран хамгаалах, хариуцах үүргээс гадуурх хүүхэдтэй шаардлагагүй холбоо барих.
- ✗ Хувцас солих өрөө, ариун цэврийн өрөөнд гар утсаараа зураг авах, видео бичлэг хийх.
- ✗ Зөвшөөрөл авсан зүйлээс гадуур хүүхэд, залуу хүний зураг, мэдээллийг бүртгэх, хадгалах, түгээх.
- ✗ Ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэхийг хориглож, дуугүй болгох.
- ✗ Согтууруулах ундаа, хууль бус мансууруулах бодис хэрэглэсэн үедээ хүүхэд, залуучуудтай харилцах.

